



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж,  
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам"-ын 6.2.1, 6.2.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Дорнод аймаг дахь шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 14,100,000.00 (арван дөрвөн сая нэг зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж, Дорнод аймаг дахь шүүхийн Тамгын газрын дарга Ц.Мөнхсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000259

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 04 дугаар сарын 3-ны өдрийн  
13 дугаар тогтоолын хавсралт

Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Дорнод аймгийн шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж данснаас хасах автомашин

6096169 - 1116262983

д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэх өртөг
1	Митсубиши Пажеро ММС, 00-27 ДОА дугаартай, Арлын дугаар- V434104079	1995/2008	159972	14,100,000.00	14,100,000.00	-
				<b>14,100,000.00</b>	<b>14,100,000.00</b>	-
				(арван дөрвөн сая нэг зуун мянган)	(арван дөрвөн сая нэг зуун мянган)	-